

АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ НИЙСЛЭЛИЙН 2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ  
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН ЖИЛИЙН ЭЦСИЙН ТАЙЛАН  
/НИЙСЛЭЛИЙН СПОРТЫН ХОРОО/

2020 оны 12 дугаар сарын 24

Үндэсний хөтөлбөрт тусгагдсан үйл ажиллагаа	№	2020 онд хэрэгжүүлэх арга хэмжээ	Гүйцэтгэл, хувь	Дэлгэрэнгүй тайлбар, /хэрэгжүүлээгүй шалтгаан/
Нэг. Шударга хариуцлагатай, ил тод албыг бэхжүүлэх замаар эрсдэлээс урьдчилан сэргийлэх, төрийн жинхэнэ албан хаагчийн сонгон шалгаруулалт болон томилгоонд улс төрийн нөлөөллөөс ангид, мэдлэг боловсролд суурилсан мерит зарчмыг хэрэгжүүлэх зорилтыг хангах чиглэлээр				
4.1.1.1. Төрийн албаны төв байгууллагын дүгнэлт, хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хянасан байдлыг үндэслэн албан тушаалд томилох тухай хуулийн хэрэгжилтийг хангах, хариуцлагыг дээшлүүлэх	1.	Авлигын эсрэг хуулийн үйлчлэлд хамаарч байгаа албан тушаалтнуудын хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын шинэчилсэн мэдүүлгийг бүртгэж баталгаажуулна.	Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлэг гаргах үүрэг бүхий 3 албан тушаалтны шинэчилсэн мэдүүлгийг 2020 оны 02 дугаар сарын 05-ны өдөр буюу хуулийн хугацаанд гаргуулан бүртгэж баталгаажуулсан. Хэрэгжилт 100%	
	2.	Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг (ХАСУМ)-ийг хянасан дүгнэлт, төрийн албаны зөвлөлөөс баталсан албан тушаалын тодорхойлолтыг олон нийтэд ил тод, нээлттэй болгоно.	Байгууллагын шинэчилсэн бүтцийн дагуу ахлах мэргэжилтэн А.Болдмаа, мэргэжилтэн С.Саранцэцэг нарыг 2017 онд хэлтсийн даргаар дэвшүүлэн, удирдах ажилтныг сонгон шалгаруулах шалгалтад хамруулан, ХАСУМ-ыг АТГ-аар урьдчилан хянуулж томилох ажлыг зохион байгуулсан. Нийслэлийн Засаг даргын 2019 оны А/241 дүгээр захирамжаар Нийслэлийн Спортын хороо 2 хэлтэс, 16 хүний бүрэлдэхүүнтэй байхаар орон тооны хязгаарыг батласны дагуу албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн боловсруулж, Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн 2020 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн “Зөвшөөрөл олгох тухай” 104 дүгээр тогтоолоор батлуулсан. Тус тогтоолын дагуу байгууллагын даргын 2020 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн А/11 дүгээр	

			тушаалаар төрийн захиргааны 13 албан хаагчдын албан тушаалын тодорхойлолтыг баталж шинээр үүссэн 4 сул орон тоог нөхөн бүрдүүлэх зорилгоор нийтэд нээлттэй зарлаад байна. Хэрэгжилт 100%	
4.4.1.2. Нийтийн албанд томилогдох албан тушаалтны ёс зүй, мэдлэг, боловсрол, туршлага, ур чалдварын шалгуурыг олон улсын жишигт нийцүүлэн шинэчлэх, албан тушаалтныг мэлээг, боловсролд суурилсан мерит зарчмыг баримтлан томилох, дэвшүүлэх	3.	Албан тушаалтанд тавигдах ёс зүй, мэдлэг боловсрол, туршлага, ур чадварын ерөнхий болон тусгай шалгуурыг үндэслэн дэвшүүлэн томилно.	Тус хорооны Спортын барилга байгууламж, хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан мэргэжилтний албан тушаалын сул орон тоонд тус хорооны мэргэжилтнээр ажиллаж байсан Б.Оюунтуяа төрийн албаны тусгай шалгалт өгч тэнцсэн тул Төрийн албаны зөвлөлийн Нийслэл дэх салбар зөвлөлийн 2020 оны 10 дугаар сарын 08-ны өдрийн 41 дүгээр тогтоолыг үндэслэн байгууллагын даргын 2020 оны Б/22 дугаар тушаалаар томилон ажиллуулсан. Хэрэгжилт 100%	
	4.	Төрийн албан хаагчийн албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн батлуулна.	Нийслэлийн Засаг даргын 2019 оны А/241 дүгээр захирамжаар Нийслэлийн Спортын хороо 2 хэлтэс, 16 хүний бүрэлдэхүүнтэй байхаар орон тооны хязгаарыг батласны дагуу албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн боловсруулж Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн 2020 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн “Зөвшөөрөл олгох тухай” 104 дүгээр тогтоолоор батлуулсан. Тус тогтоолын дагуу байгууллагын даргын 2020 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн А/11 дүгээр тушаалаар төрийн захиргааны 13 албан хаагчдын албан тушаалын тодорхойлолтыг баталж шинээр үүссэн 4 сул орон тоог хуулийн дагуу нөхөн бүрдүүлэх зорилгоор ажлын байрыг нийтэд нээлттэй зарлаад байна. Хэрэгжилт 100%	

	5.	Төрийн жинхэнэ албан тушаалын мэдлэгийн шалгалтыг зохион байгуулна.	Төрийн албан тушаалын мэдлэгийн шалгалтад байгууллагын 8 албан хаагч хамрагдан 70-87% үзүүлэлт үзүүлсэн байна. Хэрэгжилт 100%	
4.1.1.3. Олон улсын жишигт нийцсэн гүйцэтгэлийн үнэлгээний нэгдсэн тогтолцоог бүрдүүлж, нийтийн албан тушаалтны үйл ажиллагааг үнэлэх, дүгнэх, хариуцлага тооцох арга, хэлбэрийг шинэчлэн тодорхойлох эрх зүйн зохицуулалтыг бий болгох	6.	Төрийн албан хаагчийн үйл ажиллагааг үнэлэх, дүгнэх, хариуцлага тооцох олон улсын тогтолцоо (ISO 9000)-г нэвтрүүлэх ажлыг шат дараалалтай хэрэгжүүлнэ.	Байгууллагын албан хаагчидтай үр дүнгийн гэрээ байгуулан бүтэн жилээр, гүйцэтгэлийн төлөвлөгөөг улирал бүрээр гаргуулан дүгнэж үр дүнг харгалзан урамшуулал олгох ажлыг хэрэгжүүлсэн. Хэрэгжилт 100%	
4.1.1.5. Авлигын эрсдэлийн үнэлгээний аргачлалыг баталж, хэрэгжилтэд дүн шинжилгээ хийж хэвшүүлэх	7.	Авлигын эрсдэлийн үнэлгээ хийж, эрсдэлээс хамгаалах арга хэмжээ авна.	Байгууллагын ажлын байруудад авлигын эрсдэлийн үнэлгээг батлагдсан аргачлалын дагуу хийх ажлыг 2021 онд зохион байгуулна. Хэрэгжилт 100%	
4.1.1.6. Нийтийн албаны ёс зүйн үлгэрчилсэн дүрмийг батлах, ёс зүйн зөрчилд дүн шинжилгээ хийх, шалтгаан нөхцөлийг тогтоох, арилгах, тайлагнах, хэлэлцүүлэх ажлыг хэвшүүлэх	8.	Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд дүн шинжилгээ хийх, шалтгаан нөхцөлийг тогтоох, хэлэлцүүлэх ажлыг зохион байгуулна.	2020 оны 2-р сард байгууллагын ажилтнуудын дунд төрийн албан хаагчийн ёс зүйн асуудлаар хэлэлцүүлэг зохион байгуулж, байгууллагын ёс зүйн дүрмийг шинэчлэн баталж мөрдлөгө болгон ажилласан. Хэрэгжилт 100%	
4.1.1.7. Нийтийн албан тушаалтанд холбогдох авлига, ашиг сонирхол, ёс зүйтэй холбоотой гомдол, мэдээллийг хүлээн авах, хянан шалгах, хариуцлага	9.	Албан тушаалтанд холбогдох авлига, ашиг сонирхол, ёс зүйтэй холбоотой гомдол, мэдээллийг хүлээн авах, хянан шалгах, хариуцлага хүлээлгэх үйл ажиллагааг	Авлигын эсрэг хуулийн хэрэгжилт, албан тушаалтанд холбогдох авлига, ашиг сонирхол, ёс зүйтэй холбоотой гомдол, мэдээллийг хүлээн авах, хянан шалгах, хариуцлага хүлээлгэх үйл ажиллагааны талаарх хууль тогтоомжийг	

хүлээлгэх арга хэлбэрийг тодорхой болгож, дотоод хяналтын тогтолцоог бүрдүүлэх		мэдээллийн олон эх үүсвэрээр хүлээн авч шийдвэрлэнэ.	байгууллагын сайт, мэдээллийн самбарт байршуулж ажилласан.  Хэрэгжилт 100%	
4.1.1.9. Төрийн байгууллага хоорондын хамтын ажиллагааг хөгжүүлж, мэдээлэл солилцох нөхцөл боломжийг сайжруулах	10.	Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудаас үзүүлж байгаа 46 үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлнэ.	Байгууллагаас зохион байгуулж буй биеийн тамир, спортын арга хэмжээнд оролцогчдын мэдүүлэг бүртгэлийг цахимаар хүлээн авах шийдвэрлэх ажлыг хэрэгжүүлж байна. Дэлхий нийтийг хамарсан шинэ төрлийн Коронавирус /COVID-19/ гарч халдвараас иргэд, олон нийтийг хамгаалах, урьдчилан сэргийлэх зорилгоор улсын хэмжээнд онцгой дэглэм тогтоосонтой холбогдуулан иргэдийг хөдөлгөөний хомсдолоос урьдчилан сэргийлэх зорилгоор бүх насны иргэдэд зориулсан олон төрлийн идэвхтэй хөдөлгөөн, спортын техник сургалтуудыг цахимаар зааж сургах ажлыг 2020 оны 3 дугаар сараас тогтмол зохион байгуулж байна.  Хэрэгжилт 100%	
4.1.1.10. Нийтийн албаны сургалтын институт байгуулах, албан тушаалтныг давтан сургах боломжийг бүрдүүлэх	11.	Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын төрийн албан хаагчдад зориулсан Авлигын эсрэг сургалт, давтан сургалтыг зохион байгуулна.	Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын төрийн албан хаагчдад зориулан танхимаар болон цахимаар зохион байгуулсан Авлигын эсрэг сургалтуудад байгууллагын 9 албан хаагчийг хамруулсан. Мөн 2020 оны 12 дугаар сарын 22-23-ны өдрүүдэд АТГ-аас цахимаар зохион байгуулсан ЭБАТ-ны сургалтад хорооны хэлтсийн дарга А.Болдмаа хамрагдлаа.  Хэрэгжилт 100%	
Хоёр. Төрийн үйлчилгээний нээлттэй байдлыг хангаж, цахим үйлчилгээг хөгжүүлж, чанар хүртээмжийг сайжруулах, үйлчлүүлэгчдийн эрх ашгийг дээдэлж, төрийн албан хаагчийн хариуцлагыг дээшлүүлэх зорилтыг хангах чиглэлээр				
4.1.2.6. Өргөдөл гомдол, мэдээлэл өгөх ил тод	19.	Иргэдээс нийслэлийн нутгийн захиргааны байгууллага,	2020.01.01-нээс 2020.12.25-ны хооронд иргэдээс ирүүлсэн 1 санал, 2 гомдол, 9 хүсэлтийн индекс	

<p>нээлттэй суваг ажиллуулах, өргөдөл, гомдол мэдээллийг цахим хэлбэрээр гаргах, шийдвэрлэх, хяналт тавих нөхцөл боломжийг бүрдүүлэх</p>		<p>албан тушаалтанд гаргасан өргөдөл гомдлыг хүлээн авах эх үүсвэрийг нэмэгдүүлж, шийдвэрлэлтийн чанар, үр дүнг сайжруулна.</p>	<p>тооцсон үзүүлэлт -0.05, нийслэлийнхээс -0.14-өөр бага, 88 буюу “А” үнэлгээтэй үнэлэгдсэн байна.</p> <p>Хэрэгжилт 100%</p>	
	20.	<p>Нийслэлийн нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл гомдлыг шийдвэрлэх журмыг шинэчлэн батлуулж, дотоод удирдлагын нэгдсэн UB ERP системийн өргөдөл, гомдлын дэд цэсний хөгжүүлэлтийн ажлын даалгаврыг боловсруулж, програм хангамжийн сургалтуудыг зохион байгуулан ажиллана.</p>	<p>Байгууллагын удирдлага, ажилтнуудад өргөдөл, гомдлыг шийдвэрлэх явцдаа явцын тэмдэглэлийг хөтөлж байхыг зөвлөх, хяналт тавих, 14 хоног тутмын мэдээ гаргах, алдаа дутагдал, зөрчлийг арилгуулах зэрэг ажлуудыг тухай бүр гүйцэтгэж ажиллалаа.</p> <p>Байгууллагад иргэдээс ирсэн өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн явц, шийдвэрлэсэн тайлан мэдээг ERP системийн өргөдөл гомдлын дэд цэсэнд тухай бүр нь байршуулсан.</p> <p>Хэрэгжилт 100%</p>	
	21.	<p>Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудад иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг хууль зүйн үндэслэлтэй нэг мөр эцэслэн шийдвэрлүүлж, хуулийн хугацаанд иргэнд хариу өгөх жишгийг тогтооход анхаарч ажиллана.</p>	<p>2020.01.01-нээс 2020.12.25-ны хооронд манай байгууллагад иргэдээс ирүүлсэн 1 санал, 2 гомдол, 9 хүсэлтийг өдөрт нь удирдлага, холбогдох ажилтнуудад шилжүүлж, шийдвэрлэлтийн мэдээг 14 хоног бүр байгууллагын удирдлагад танилцуулж, мэдээлэл хийснээр өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн дундаж хугацааг нийслэлийн дундаж хугацаанд хүргэн 3 хоног 6 цаг 18 минут болгосон.</p> <p>Хэрэгжилт 100%</p>	
	22.	<p>Олон нийтийн сүлжээгээр иргэдээс ирүүлж буй нийтийн эрх ашиг зөрчигдөж, эцэслэн шийдвэрлэгдэхгүй байгаа өргөдөл, гомдлыг шийдвэрлүүлж, иргэнд хариу өгнө.</p>	<p>2020 онд манай байгууллагын нэр дээр олон нийтийн сүлжээгээр ирүүлсэн өргөдөл гомдол бүртгэгдээгүй байна.</p> <p>Хэрэгжилт 100%</p>	

	23	Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжид хөндлөнгийн үнэлгээ хийлгэнэ.	Байгууллагын үйл ажиллагаатай холбоотой асуудлаар 700 гаруй иргэдийн дунд санал асуулга явуулж дүн шинжилгээ хийж байгууллагын үйл ажиллагаа төлөвлөгөөнд тусган ажилласан. Хэрэгжилт 100%	
	24	Төрийн албан хаагчийн үйл ажиллагааг иргэн үнэлэх тогтолцоог нэвтрүүлнэ.	Нийслэлийн 700 гаруй иргэдээс авсан судалгаа, санал асуулгын дүнгээр биеийн тамир, спортын үйл ажиллагааны удирдлага зохион байгуулалт, чанар, хүртээмжийг хангалттай гэж үнэлсэн. Хэрэгжилт 100%	
Гурав. Төсөв санхүү, аудитын үйл ажиллагааны удирдлага, хяналтыг сайжруулах, ил тод байдлыг хангах, төсвийн хөрөнгө, гадаадын зээл, тусламжийг үр ашигтай, зориулалтын дагуу зарцуулах, хариуцлагыг дээшлүүлэх зорилтыг хангах чиглэлээр				
4.1.3.1. Улсын болон орон нутгийн төсөв, санхүүгийн удирдлагын тогтолцоог сайжруулах, ил тод, нээлттэй, хариуцлагатай байх зарчмыг мөрдүүлэх	25.	Улсын болон орон нутгийн төсөв, санхүүгийн удирдлагын одоогийн тогтолцоонд дүн шинжилгээ хийж, оновчтой бүтцийг бий болгоно.	МУ-ын Засгийн газрын 2020 оны 47-р тогтоолоор МУ-ын Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээнд Засгийн газрын тохируулагч агентлаг - Биеийн тамир, спортын Улсын хороог байгуулж 21 аймаг, нийслэл, дүүргийн БТС-ын хороодыг хамааруулах болсоноор 2021 оноос санхүүгийн босоо тогтолцоонд шилжиж байна. Хэрэгжилт 100%	
	26.	Гадаадын зээл тусламж, Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжих хөрөнгө оруулалт болон төсөл хөтөлбөр, арга хэмжээ бүрийн явц, гүйцэтгэлийг цахимаар хянах орчныг бүрдүүлж, нээлттэй, ил тод болгох, мэдээллийг сайжруулна.	“Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр төсөл”-ийн хүрээнд Сонгинохайрхан дүүргийн 40-р хороо Баянхошуу дэд төв 650 хүний суудалтай спорт цогцолбор, Сүхбаатар дүүргийн 17-р хороо Дамбадаржаа дэд төв 400 хүний суудалтай спорт цогцолбор, Баянзүрх дүүргийн 24 хороо 400 хүний суудалтай спорт цогцолборуудыг барьж байгуулах зураг төслийг боловсруулан хөтөлбөрт тусгуулан мэдээллийг цахим хуудсандаа байршуулан ажилласан. Хэрэгжилт 100%	

<p>4.1.3.3. Засгийн газрын тусгай сангийн санхүүжилт, зарцуулалтыг ил тод, хяналттай болгох</p>	<p>27.</p>	<p>Засгийн газрын тусгай сангийн санхүүжилт, зарцуулалтын мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд “ЗГ-ын тусгай сангийн мэдээлэл” гэсэн цэсээр олон нийтэд мэдээлэх ажлыг зохион байгуулна.</p>	<p>Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний дагуу шилэн дансны “shilendans.gov.mn” цахим хуудсанд байгууллагын 2020 оны жилийн төсөв, 2019 оны санхүүгийн тайлан, аудитын дүгнэлт, 2020 оны төсвийн гүйцэтгэлийн 1, 2, 3, 4, 5, 6, 7, 8, 9, 10, 11, 12-р сарын мэдээ, цалингаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш орлого, зарлагын гүйлгээ зэрэг 20 төрлийн 145 мэдээ, мэдээлэл, тайланг цахимд, 8 төрлийн мэдээллийг самбарт байршуулсан.</p> <p style="text-align: right;">Хэрэгжилт 100%</p>	
<p>4.1.3.4. төсвийн төсөл хэлэлцэхэд олон нийтийн оролцоог хангах</p>	<p>29.</p>	<p>Нийслэлийн 2021 оны төсвийн төслийн талаар хэлэлцүүлэг өрнүүлэх, төсвийн төсөлд олон нийтийн саналыг авч тусгах ажлыг зохион байгуулна.</p>	<p>МУ-ын Засгийн газрын 2020 оны 47-р тогтоолоор МУ-ын Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээнд Засгийн газрын тохируулагч агентлаг - Биеийн тамир, спортын Улсын хороог байгуулж 21 аймаг, нийслэл, дүүргийн БТС-ын хороодыг хамааруулах болсоноор 2021 оноос санхүүгийн босоо тогтолцоотой болж байна. 2021 оны нийслэл, дүүргийн төсвийн төслийн хэлэлцүүлгийг өргөн хүрээнд зохион байгуулж, төслийг боловсруулан БТСУХороонд хүргүүлсэн.</p> <p style="text-align: right;">Хэрэгжилт 100%</p>	
<p>4.1.3.6. Нийтийн албаны санхүүгийн дотоод аудит, хяналт шалгалтын үйл ажиллагаа, хариуцлагын тогтолцоог боловсронгуй болгох</p>	<p>30.</p>	<p>Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудад дотоод аудит, хяналт шалгалтыг хийх, дүгнэлт, зөвлөмж өгнө.</p>	<p>Нийслэлийн аудитын газраас байгууллагын үйл ажиллагаанд 2019 онд дотоод аудит хийсэн. Байгууллагын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд Нийслэл дэх төрийн аудитын газраар аудит хийлгэж өгсөн зөвлөмжийн дагуу төлөвлөгөө гарган ажилласан.</p> <p style="text-align: right;">Хэрэгжилт 100%</p>	

<p>4.1.3.7. 2020 оны 47-р тогтоолоор Монгол улсын Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээнд ЗГ-ын тохируулагч агентлаг - Биеийн тамир, спортын Улсын хороог байгуулж, Аудитын дүгнэлтийн дагуу авах арга хэмжээ, хариуцлагын тогтолцоог сайжруулах</p>	<p>32.</p>	<p>Нийслэлийн төсвийн ерөнхийлөн захирагчийн хамрах хүрээний байгууллагуудын удирдлага, санхүү хариуцсан албан хаагчдад төсвийн зарцуулалтын үр ашгийг дээшлүүлэх чиглэлээр сургалт зохион байгуулна.</p>	<p>Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас зохион байгуулсан төсвийн зарцуулалтын үр ашгийг дээшлүүлэх сургалтад байгууллагын дарга, нягтлан бодогч нар хамрагдсан.</p> <p style="text-align: right;">Хэрэгжилт 100%</p>	
<p>Долоо. Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд иргэд, олон нийтийн хяналт, иргэний нийгмийн байгууллагын үүрэг, оролцоог нэмэгдүүлэн, идэвх санаачлагыг дэмжих зорилтыг хангах чиглэлээр</p>				
<p>4.1.7.1. Төрийн бодлого боловсруулах, хэлэлцэх, батлах зэрэг шийдвэр гаргах бүх шатанд тухайн асуудлаар үйл ажиллагаа явуулдаг иргэний нийгмийн байгууллагыг татан оролцуулах замаар авлигатай тэмцэх, авлигаас урьдчилан сэргийлэхэд иргэний нийгмийн байгууллагын оролцоог дэмжих</p>	<p>36.</p>	<p>Нийслэлийн хэмжээнд авлигын нийгмийн хор аюулыг ухуулан таниулах, авлигыг үл тэвчих үзлийг төлөвшүүлэх ажлыг иргэний нийгмийн байгууллага, олон улсын байгууллагатай хамтран зохион байгуулна.</p>	<p>Нийслэлийн хэмжээнд авлигын нийгмийн хор аюулыг ухуулан таниулах, авлигыг үл тэвчих үзлийг төлөвшүүлэх, иргэдэд сурталчлах ажлыг өөрийн байгууллагатай хамтран ажилладаг ТББ, спортын холбоодтой хамтран хэрэгжүүллээ.</p> <p style="text-align: right;">Хэрэгжилт 100%</p>	
<p>4.1.7.3. Төрийн байгууллага, түүний удирдлагын үйл ажиллагаанд төрийн бус байгууллага хяналт тавих боломжийг бий болгох, төрийн зарим ажил үйлчилгээг төрийн бус</p>	<p>38.</p>	<p>Төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлж, төсвөөс олгож байгаа санхүүжилтийн зарцуулалтыг ил тод, нээлттэй болгож, нийтэд мэдээлнэ.</p>	<p>Тус хорооноос спортын 16 холбоодтой гэрээ байгуулан ажиллаж тухайн спортыг нийслэлийн хэмжээнд хөгжүүлэх Улаанбаатар хотын аварга шалгаруулах тэмцээнийг зохион байгуулах ажлуудыг хамтран хэрэгжүүлж гүйцэтгэлийн болон санхүүгийн тайланг байгууллагын шилэн дансны мэдээлэлд байршуулан ажилласан.</p> <p style="text-align: right;">Хэрэгжилт 100%</p>	



байгууллагаар гүйцэтгүүлэх, санхүүжилтийг ил тод, үр ашигтай зарцуулах, түүнд хяналт тавих тогтолцоог бүрдүүлэх				
Арав. Шударга ёсны үзэл санааг төлөвшүүлэн олон нийтийг соён гэгээрүүлэх үйл ажиллагааг үе шаттай зохион байгуулж, авлигын эсрэг боловсролыг дээшлүүлэх зорилтыг хангах чиглэлээр				
4.1.10.1. Авлигын нийгмийн хор аюулыг ухуулан таниулах, авлигыг үл тэвчих үзлийг төлөвшүүлэхэд иргэн, төрийн болон төрийн бус байгууллагын оролцоог хангах арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлэх	39.	Авлигын нийгмийн хор аюулыг ухуулан таниулах, авлигыг үл тэвчих үзлийг төлөвшүүлэх зорилгоор иргэдэд зориулсан дүрст сурталчилгааг хийнэ.	Авлигатай тэмцэх газар, нийслэлээс авлигын эсрэг гаргасан мэдээ мэдээлэл, зурагт мэдээлэл, зөвлөмжүүдийг байгууллагын цахим хуудас, мэдээллийн самбарт байршуулан нийтэд сурталчиллаа.  Хэрэгжилт 100%	
	40.	Авлигын эсрэг хууль, тогтоомжийг сурталчилах үйл ажиллагааг зохион байгуулах чиглэлээр дүүргийн Иргэний танхим болон эрх зүйн туслалцаа үзүүлэх төвтэй хамтран ажиллана.	Нийслэлийн Спортын хорооноос зохион байгуулсан 5 удаагийн сургалтын хөтөлбөрт авлига, төрийн албаны ёс зүйн холбогдолтой мэдээ мэдээллийг тусган 500 гаруй хүнд хүргэх ажлыг хийлээ.  Хэрэгжилт 100%	

ТАНИЛЦСАН:  
НИЙСЛЭЛИЙН СПОРТЫН ХОРООНЫ ДАРГА

Ж.ГАНБОЛД

ХЭРЭГЖИЛТ ГАРГАСАН:  
БИЕИЙН ТАМИРЫН ХӨГЖЛИЙН  
ХЭЛТСИЙН ДАРГА

А.БОЛДМАА